



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/323

Алтай хот

“Дархлаажуулалтын 10 хоног” зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/180 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг аймгийн хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 09-ний өдрүүдэд “Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье” уриан дор зохион байгуулж, 10 сартайгаас 8 настай хүүхдүүдийг улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар нэмэлтээр дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулсугай.


2. “Дархлаажуулалтын 10 хоног”-ийн хугацаанд нэмэлт дархлаажуулалт хийх бэлтгэл ажлыг хангуулах, шаардагдах хүн хүч, шатахуун, халдваргүйтгэлийн бодис, ороох боох материал зэрэг зардлыг тооцон санхүүжүүлж, харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд чанартай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн судалгааг гарган, аюулгүй дархлаажуулалт явуулах нөхцөл боломжоор хангаж, дархлаажуулалт, түүний дараах урвал хүндрэлээс сэргийлэх зөвлөмж, сурталчилгааг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. “Дархлаажуулалтын 10 хоног”-ийн үйл ажиллагааны мэдээ болон иргэдэд зориулсан зөвлөмж, сурталчилгааг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

